

## ЕЛЮЙ ЧУЦАЙН ТАЛААР ӨГҮҮЛЭХ НЬ

Н.Төмөр\*

Монголын эзэнт гүрний үед нэр цууд гарсан төр улс, бичиг соёлын болон цэргийн өдий төдий зүтгэлтний нэг нь Кидан угсааны Елюй Чуцай байжээ.

Елюй Чуцай нь Алтан улсын нийслэл Яньцзинд (одоогийн Бээжин хот) төрийн алба хааж байсан ба 1215 онд Яньцзин хот Чингис хааны цэрэгт эзлэгдэх үед Елюй Чуцай ч хаанд олзлогджээ. Тэрээр хаанд бараалхахад дуу нь яруу тунгалаг, бие нь найман тохой өндөр, сахал нь маш урт, өтгөн сайхан харагдаж, ихэд таалагдсан учир Чингис түүнийг дэргэдээ байлган, зөвлөх түшмэлээр ажиллуулах болжээ. Чингис хаан Елюй Чуцайд их дотно сайн байсан учраас түүнийг нэрээр нь биш, урт сахалт хэмээн дууддаг байлаа. Елюй Чуцай Монголын төрд хүчин зүтгэх болж, өндөр албан тушаал эзлэн Чингис, Өгэдэй нарт Монголын төрийн хэрэг явдал болоод ялангуяа эзлэгдсэн орнуудыг хэрхэн захирах талаар чухал зөвлөгөө өгч байсан бөгөөд Монголын хаад ч түүнийг зөвлөмж саналыг харгалздаг байсан билээ (I—XI — 3455—3465; 2—230; 3—299).<sup>2</sup>

Елюй Чуцай, эцэг Елюй Лью-г 60 настай байхад нь буюу Алтан улсын Ваньянь Цзин хааны /1168—1208/, /1189 оноос эхлэн бүгд 19 жил хаан ширээнд суусан/, хоёрдугаар оны 6-р сарын 20-нд (1190 оны 7-р сарын 24-нд) Яньцзинд төрсөн. Елюй Чуцайн төрсөн он сар өдрийг түүхийн сурвалж бичигт дурдсан мөртөө тэрээр чухам хаана төрсөн талаар ном сурвалжид бичсэн тодорхой зүйлгүй боловч Елюй Чуцайг төрөхөд эцэг Елюй Лью нь Алтан улсын баруун тэргүүн сайдын алба хааж, ар гэр нь Алтан улсын нийслэл Яньцзинд байсан зэрэг учир шалтгааныг үндэслэн Елюй Чуцайг Яньцзинд төрсөн хэмээн үзэж байна (4—57; 5—362; 6—1—215)). Тэрээр 55 насалж, Өгэдэй хааны дараа Монголын төр түр хамаарсан Туракина хатны<sup>3</sup> 3-р онд буюу Хөх луу жилийн 5-р сарын 14-нд (1244 оны 6-р сарын 20-нд), Хархорумд нас баржээ (5—365; 4—57; I—XI—3464).

Елюй Чуцай нь Ляо улсын (947 онд кидан нарын байгуулсан улс (2—154; 7—1—59; 8—42)) хараат улс болох Дорнод Дан улсын ван Елюй Туюгийн жилийхүй (наймдугаар үеийн ач хүү (16—10)) байсан билээ (1—XI-3464).

Елюй Туюй (909—946) бол кидан аймгийн тэргүүлэгчийг гурван жил тутам сонгох журам зөрчин 917 онд Киданы хаан болж, хаан төрийн ширээг үе улиран залгамжлах болгосон Амбагян хааны (Амба гян 917 онд Киданы хаан болсон хэмээн БНМАУ-ын түүхийн номонд

\* Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан.

2 Хаалтанд байгаа тооны эхнийх нь ашигласан номын нэр (сэдвийн хойно жагсаасан), 2-рх нь тухайн номын хуудсыг заасан болно. Зарим эх сурвалж олон дэвтэртэй тул дундах буюу ром тоогоор дэвтрийн дугаарыг заав. 3 Туракина хатан бол Өгэдэй хааны 6-р хатан, Гюг хааны (1206— 1248) төрсөн эх юм. Туракина нь мэргэд угсааны хүн, Өгэдэй хаан 1241 оны 12-р сарын 11-нд нас барсны дараа Туракина хатан нөлөө бүхий ноёд, түшмэдийг Даландаваанд хуралдуулан шинэ хаан өргөмжлэх асуудал хэлэлцүүлсэн боловч чухам хэнийг өргөмжлөх тухай тодорхой шийдвэр гаргалгүй Туракина хатанд төр хамааруулахаар тогтжээ. Туракина 4 жил гаруй хугацаагаар Монгол улсын төрийг хамаарч, 1246 оны зун болсон хаан өргөмжлөх хурилдайд арга буюу ороо тавьж, хүү Гюгийг хаан ширээнд суулгасан билээ (1—X-2870; 3—447; 2—259 -6 дахь тал, дахь тал, 264).

бичжээ (2-153). Харин Хятадын түүхийн ном болон холбогдох толь бичгүүдэд Амбагян 916 онд хаан болж, Кидан улсыг байгуулсан гэж тэмдэглэсэн байна (8-25; 3—131; 9—646)) ахмад хөвгүүн байсан юм. Тэрээр кидан, хятад хэл болоод бичиг сайн мэддэг байсан учир дээр дурдсан хэлээр их хэмжээний ном зохиол уншиж, шүлэг болон дууны үг зохион бичдэг байснаас гадна зурхайн ухаан, анагаах эмийн зүйн талаар нэлээд мэдлэг боловсролтой, хөгжим тоглож, зураг зурдаг байсан ба ялангуяа Кидан үндэстний ахуй амьдралыг харуулсан уран зургийг бүр ч сайхан зурдаг байлаа. Бурхны шашнаас илүү Күнзийн сур таалыг Елюй Туюй тахин шүтдэг байсан тухай зарим ном сурвалжид дурджээ (7—V—1209—1211; 8—38; 3—291).

Амбагян хаан 926 онд Хятадын зүүн хойд талд оршиж байсан Бохай хэмээх улсыг мөхөөж оронд нь Дорнод Дан гэдэг Кидан гүрний хараат улсыг байгуулан, Елюй Туюй хүүгээ тус улсын ван буюу эзэн захирагчаар томилжээ. Елюй Туюй Дорнод Дан улсыг захирахдаа Бохай улсын хуучин дэг журмыг сахиулан, хятад арга хэрэглэж байсан билээ (7-V—1210; 3—102). Амбагян хаан Бохай улсыг эзлэн мөхөөж, түүний оронд Дорнод Дан улсыг байгуулсны дараа эх нутагтаа буцаж явах замдаа Фууй (одоогийн Өвөр Монголын Баарин зүүн хошууны баруун талд орших газрын нэр) хэмээх газарт нас баржээ. (7-1—23; 3—131). Амбагян хааны дараа зүй ёсоор нь түүний ахмад хөвгүүн Елюй Туюй хаан ширээнд үе залгамжлан суух байлаа. Учир нь Амбагян хаан 916 оны хавар Елюй Туюйг хаан хүү болгон өргөмжилсөн юм (7—V—1209). Гэвч тэр үед төр түр хамаарч төр, цэргийн эрхийг гартаа авсан Амбагян хааны хатан буюу Елюй Туюйн эх Шулуй хатан нь ахмад хөвгүүн Елюй Туюйг хаан ширээнд суулгах дургүй, харин түүний дүү буюу Амбагян хааны хоёрдугаар хүү Елюй Яогу-г хаан болгох бодлоготой байсныг Елюй Туюй нэгэнт мэдэж байлаа (7 I—23; 7—V-1200—1210).

Елюй Туюй өөрийгөө хаан болж чадахгүйгээ ойлгосноор ая тал засаж, ноёд түшмэдийг дагуулан Шулуй хатанд айлтгахдаа, Елюй Яогу бол хааны хөвгүүн бөгөөд их жанжин, түүний байгуулсан гавьяаг хүн бүхэн мэдэх учраас Елюй Яогу-г хаан ширээнд суулган, улс орноо түүнд захируулбал зохино хэмээжээ (7—1—28; 7-V-1210). Дээр дурдсан учир шалтгаанаар Амбагян хааны дараа Елой Яогу 927 онд Кидан улсын хаан болжээ (7—1—28; 7—V—1210). Елюй Яогу хаан ширээнд суусны дараа ах Елюй Туюйг Дорнод Дан улсын вангаас огцруулан, Кидан улсын өмнөд нийслэл болох Дунпин фу-д (одоогийн БНХАУ-ын Ляонин мужийн Ляоян хот. Дунпин фу нь эхлээд (928 онд) Кидан улсын өмнөд нийслэл, дараа нь (938 онд) дорнод нийслэл болжээ (10—44; 11—480)) нутаг зааж, хүчээр нүүлгэснээр үл барам, хамгаалах цэргээ нууцаар илгээж Елюй Туюйг туршин тагнаж байсан билээ (7—V—1210). Елюй Туюй дээрх байдлыг үл тэвчин, Тэгээд ч Хожуу Тан улсын (Хятадын түүхэнд байсан таван төр арван улсын үед Хятадын төв хэсгийн газар нутагт (923—936 онд) оршин тогтнож байсан улсын нэр (9-928)) хаан Ли Сиюань түүнийг Хожуу. Тан улсад ирэхийг урьсан учир хатантайгаа хамт Хожуу Тан улсад орогнохоор очжээ (7—V—1210; 12—1—140). Елюй Туюй 946 онд буюу 38 настай байхдаа Хожуу Тан улсын хаан Ли Сиюаний өргөмөл хүү Ли Цункэд алуулжээ (7-V—1211).

Елюй Чуцайн холбоо (долоодугаар үеийн өвөг эцэг (16—10)) Елюй Лоуго (? —952) (3—297) нь Дорнод Дан улсын ван Елюй Туюйн хоёрдугаар хүү (7-V-1211), Удинцзюн (одоогийн БНХАУ-ын Шэньси мужийн Ян сяний нутаг дэвсгэрт оршиж байсан газрын нэр) хэмээх газрын захирагч байсан бөгөөд 951 онд Ляо улсын хаан Елюй Шулуйг

(931-969) (3—133) хаан ширээнд суухад онцгой гавьяа байгуулсан хэмээн түүнийг Ляо улсын өмнөд нийслэлийн (Ляо улсын Елюй Яогу хаан 938 онд Юйчжоу хотыг (одоогийн Бээжин хот) Ляо улсын өмнөд нийслэл хэмээн зарласан ба 1012 онд Елюй Лунсуй хаан уг хотыг Яньцзин гэж өөрчлөн нэрлэх болжээ (6—572; 10—44)) Люшоу захирагчаар (хааныг эзгүй хойгуур нийслэл хотыг хамгаалан захирахаар үлдсэн түшмэлийн цол хэргэм) дэвшүүлэн томилсон тухай Ляо улсын түүх номонд бичжээ (7-V-1501). Дээр дурдсанаас үзэхэд Елюй Чуцайн холбоо Елюй Лоуго нь нэлээд өндөр соёл боловсролтой бөгөөд Ляо улсын төрд өндөр албан тушаал хашиж байсан түшмэл хүн билээ.

Елюй Чуцайн эцэг Елюй Люй нь Алтан улсын Ваньянь Юнь (1123 1189) хааны үеэс эхлэн Алтан улсын төрд алба хааж, Ваньянь Цзинь хааны (1168—1208) үед буюу 1190 оны 5-р сард Алтан улсын баруун тэргүүн сайд болон дэвшжээ (1-XI—3455; 6—1—215).

Елюй Чуцайн холбоо Елюй Лоуго-г Яньцзингийн захирагч болсон үеэс эхлэн Елюй Чуцайн өвөг дээдэс үе дамжин Яньцзинд суурьших болсон хэмээн «Цифу тунчжи» нэвтэрхий ойллогоос\* иш татан «Монголын түүхийн тэмдэглэл»-д бичсэн (5—362), Алтан улсын хаан Ваньянь Лян (1122—1161) 1153 оны 3-р сард Яньцзинг Алтан улсын нийслэл болгон зарласан (14—12), Яньцзин нь 1214 он хүртэл Алтан улсын нийслэл байсан (14—22), Елюй Чуцайн эцэг Елюй Люй 1190 онд Алтан улсын баруун тэргүүн сайд болсон ба мөн онд Елюй Чуцай, төрсөн (4-57) зэрэг нь цөм Елюй Чуцайг Яньцзинд төрснийг харуулав.

Елюй Чуцайг 3 настай байхад эцэг нь нас барсан учир тэрээр өнчрөн хоцорч, төрсөн эх Яньшигээр бичиг ном заалган, эрдэм боловсролтой болж, улмаар одон орны судлал, газарзүй, тооны ухаан, буддийн болон бумбын шашны сургаалыг судалж, эмчлэх төлөгдөх аргыг сурч, шүлэг ном зохиол бичдэг болжээ (1—XI—3455). Алтан улсын Ваньянь Цзин хааны гуравдугаар онд (1191 онд) кидан бичиг хэрэглэхийг албан ёсоор хорьсон (10—159) явдал нь Елюй Чуцайн ба гадаа кидан бичиг үсэг заалгаж чадаагүй байсан гол шалтгаан байж болох юм. Тэрээр 30 настай байхдаа буюу Чингисийн баруун зүг байлдахад дагалдан явсан үед (1219—1224) Баруун Ляо улсын сайд агсан Ли Ши Чанаар кидан бичиг үсэг заалган (15—VIII бүлгийн оршил) улмаар кидан хэлнээс хятад хэлрүү «Хөлчүү хүний үнэн дуулал» хэмээх шүлгийг орчуулжээ (15—VIII бүлгийн оршил).

Елюй Чуцайн «Номхон даяанчийн зохиолын эмхтгэл» хэмээх зохиолд бичсэнээс үзвэл, зохиогчийн үзэл санаа, ертөнцийг үзэх үзэл зэрэг нь цөм Хятадын феодалын нийгмийн уламжлалт Күнзийн сургаалтай нягт холбоотой байсан нь тодорхой байлаа. Елюй Чуцай улаан хулгана жилд (1216 онд буюу 27 настай байхдаа) бичсэн «Ядуу баясах сүмийн тэмдэглэл» хэмээх богино хэмжээний өгүүлэл нь түүний амьдралын бүх үйл ажиллагааг удирдан чиглүүлж байсан үзэл санааг харуулжээ (15-VIII — 22<sup>a, б</sup>).

1213 оны намар Чингис хаан, хүү Зүчи, Цагадай, Өгэдэй нарыг баруун замын цэрэг, дүү Хасарыг зүүн замын цэрэг, өөрөө отгон хүү Тулуйн хамт дунд замын цэргийг тэргүүлэн Алтан улсыг эзлэх дайнаа үргэлжлүүлжээ (1—1—17). 1214 оны хаврын 3-р сард Алтан улсын нийслэл Чжунду буюу Яньцзинг бүслэн авч, Алтан улсын Ваньянь Сюань хаанд элч зарж, Монголын жанжин цэрэгт бэлэг шан өргөвөл, байлдааныг зогсоож цэрэг татаж болно гэжээ (3--1--17; 1-1

\*«Цифу тунчжи» («Цифу-гийн нэвтэрхий ойллого» 120 бүлэгтэй, 1735 онд хэвлэгдсэн ном. Энэхүү нэвтэрхий ойллого нь Чжили (одоогийн БНХАУ-ын Хэбэй муж) мужийн тухай лавлах бичиг болно (13—153)

17). Тэр үед Алтан улсын хаан ихэд бачимдан сандарсан учир арга буюу Чингис хааны шаардлагыг зөвшөөрч, төрөл угсааны нэгэн вангийн охин Чиго нэртэй гүнжийг үлэмж хэмжээний алт, торго, 500 хөвүүд, охид, 3000 хүлэг морины хамт өргөж, бас Чингис хааныг нутагт буцахад нь тэргүүн сайд Ваньянь Фусинг зориуд явуулан, Цавчаал боомтоор хүндэтгэн үдэн гаргажээ (1—17). 1214 оны 5-р сард Алтан улсын хаан нийслэл хотоо Яньцзингээс Бяньцзин буюу Бяньлянд (одоогийн БНХАУ-ын Хэнань мужийн Кайфэн хот) аваачсан ба 6-р сард Чингис хаан цэргээ илгээж Яньцзинг дахин бүслэн авч нэг жилийн дараа 1215 оны 5-р сард Яньцзин хотыг бүрмөсөн эзэлжээ (1 1—17—18).

Яньцзин хот Чингис хаанд эзлэгдсэн байх үед Елюй Чуцай Яньцзингийн төрийн яаманд алба хааж байлаа (1—XI—3455). Елюй Чуцай Чингис хаанд олзлогдож, зан төрх, эрдэм боловсрол зэргээрээ хаанд таалагдсан учир түүнд хааны ордонд алба хаахыг тушаажээ (1 XI—3455). 1219 оноос эхлэн Елюй Чуцай Чингисийн баруун зүгийн буюу Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд дагалдан явав. Тэр үед Елюй Чуцайн эрх үүрэг төдий л их биш, тэр нь хэдий гээр Чингис хааны хажууд алба хааж байсан боловч хаан түүнийг чухал албан тушаалд тавьж ашиглаагүй, зөвхөн бичиг баримтын төсөл боловсруулах болон байгалийн үзэгдэл, тухайлбал, зуны цагт цас орох, өвлийн цагт тэнгэр дуугарах, мөн нар, сар хиртэх зэргийн учир шалтгааныг тайлбарлахад л ашиглаж байсан билээ (1-XI—3456). Елюй Чуцайг мөн мэргэ төлгөд ашиглаж байсан юм. Учир нь Чингис хаан дайн байлдаанд мордохынхоо өмнө заавал мэргэлүүлдэг байсан бөгөөд бусдаар мэргэлүүлснийг өөрийнхөө мэргэлсэнтэй тохирч буй эсэхийг шалгадаг зуршилтай байлаа (1—XI—3456). Дайн байлдаанд ялалт байгуулан, дайчдын урам зоригийг бадруулахын тулд мэргэ төлгө үйлдүүлж байсан нь тухайн үеийн монголчуудын шашин шүтлэгтэй холбоотой байжээ.

Дундад Азийн орнуудыг байлдан дагуулах үед Чингис хаан Елюй Чуцайг өндөр албан тушаалд тавьж ашиглаагүй байсан шалтгаан нь дор дурдсан зүйлтэй холбоотой байсан болов уу хэмээн үзэж байна. Дундад Азийн орнуудын байгалийн нөхцөл, үйлдвэрлэлийн харилцаа, хүмүүсийн ухамсар, дадал заншил зэрэг нь цөм Елюй Чуцайн төрж өссөн газар нутгийнхаас эрс өөр байсан учраас тэдгээр орныг Елюй Чуцайн баримталж байсан «Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах» онол, арга замаар үнэхээр захирч болохгүй байсан билээ. Ийм ч учраас Елюй Чуцайн «Күнзийн сургаалаар улс орныг ноёрхон захирах» талаар тавьсан удаа дараагийн санал зөвлөгөөг Чингис хаан хүлээж авсангүй. Энэ талаар Елюй Чуцай «Номхон даяанчийн зохиолын эмхтгэл» зохиолдоо нэг бус удаа дурдан бичжээ (15—XI—1<sup>6</sup>; 15 III — 13<sup>a</sup>). Чингис хааны хажууд 10 орчим жил алба хаахдаа (1218 1227) эрх үүрэг нь төдий л их биш байсанд Елюй Чуцай дургүйцэж байснаа ном зохиолдоо олон удаа илэрхийлжээ (15—II—4<sup>6</sup>; 15—III 4<sup>6</sup>). Гэвч чухал албанд тавиагүй хэмээн Елюй Чуцай сэтгэл санаагаар унаж гутарсангүй, харин ч түүний эрдэм мэдлэг, мэргэн ухааныг үнэлэн, хэзээ нэгэн цагт улс орныг захирах төрийн том байгууллагад ажиллуулна гэж ямагт итгэж байсан санаагаа илэрхийлсэн шүлгүүд «Номхон даяанчийн зохиолын эмхтгэл»-д цөөнгүй байсан билээ (15 III—12<sup>6</sup>; 15—IV— 8<sup>a</sup>).

Чингис хаан хэдийгээр Елюй Чуцайг тухайн үед өндөр албанд тавьж ажиллуулаагүй боловч дундад Азийн орнуудыг байлдан дагуулах аян дайнд олон жил хамт явсан учир их мэдлэг боловсролтой хүн болохыг нь сайн мэдэж, тааламжтай цагт түүнийг өндөр албанд дэв-

шүүлэн ажиллуулах хэрэгтэй гэж бодож байсан юм. Иймээс ч тэрээр хүү Өгэдэйд хэлэхдээ, «Энэ хүнийг тэнгэр бурхан бидэнд илгээсэн юм шүү. Хойшид түүнийг төр болон цэргийн хэрэгт оролцуулах ёстой» хэмээжээ (1—XI—3456).

Чингис хаан нас барсны дараа түүний отгон хүү Тулуй Монгол улсын төрийг түр хамаарч байсан үед Яньцингийн нийгмийн хэв журам ихээхэн сулран доройтож, энд тэндгүй дээрэм тонуул гарч байлаа. Зарим дээрэмчид баян чинээлэг айлд үхэр тэрэгтэй улаан цайм орж, үнэ цэнэтэй эд хөрөнгийг нь дээрэмдэн ачиж байхад Яньцингий захирагч ноёд ямар ч арга хэмжээ авч чадахгүй байсан болохоор Тулуй, Елюй Чуцайг бас нэг ноёнтон хамт Яньцингийн нийгэм хэв журмыг сахиулахаар томилон явуулжээ. Елюй Чуцай Яньцинд ирээд даруй дээрэмчдийг баривчлан, шүүж байцаасны эцэст тэдгээр дээрэмчний зарим нь яньцингийн захирагч ноёны төрөл төрөгсөд, зарим нь нөлөө бүхий хүмүүсийн хөвгүүд байсныг илрүүлж, өчүүхэн ч хөнгөлөлтгүйгээр хүнд ялтай 16 хүнийг цаазаар авснаар Яньцингийн замбараагүй байдлыг арилгажээ (1—X—2885; 1—XI—3475). Елюй Чуцай, Тулуйн үүрэг даалгаврыг биелүүлэхдээ ая тал засаж өндөр албан тушаалтай захирагч ноёдод зусардан бялдуучлаагүй, хэргийг үнэн шударга зөв шийдсэн явдлыг Тулуй сайшааж байсан ба үүнээс хойш Монголын дээд давхаргын ноёрхогчид Елюй Чуцайд бүр ч итгэх болж, түүнийг чухал албанд тавих болжээ.

Үргэлжлэл бий.

1. Юан улсын судар (Юаньши). Бээжин, 1976.
2. БНМАУ-ын түүх. УБ., 1966, I боть.
3. Хятадын түүхийн их толь бичиг — Ляо, Тангад, Алтан, Юан улсуудын түүх (Чжунго лиши да ыдянь — Ляс: Ся, Цзинь, Юань ши). Шанхай, 1988.
4. Су Тяньцзюе. Юан төрийн нэрт түшмэдийн хэргийн товч (Юаньчао минчэнь шилюе), 1-р дэвтэр. шанхай, 1936
5. Ту Цзи. Монголын түүхийн тэмдэглэл (Мэн-у-эр шицзи). Бээжин, 1984.
6. Алтан улсын түүх Цзиньпи). Бээжин, 1975.
7. Ляо улсын түүх (Ляоши). Бээжин, 1974.
8. Хятадын түгээмэл түүх (Чжунго тунши), 6-р дэвтэр. Бээжин, 1979.
9. Үгсийн далай (Дыхай). Шанхай, 1980.
10. Чжан Чжэннин. Киданы товч түүх, (Чидань илюе). Бээжинг. 1979.
11. Хятадын эрт эдүгээн газрын нэрсийн их толь бичиг (Чжунго гуцзинь димин да цыдянь). Шанхай, 1933.
12. Чжан Чуаси, Хятадын эртний түүхийн найруулал (Чжунго гудай шиган), доод дэвтэр. Бээжинт, 1989.
13. Үгсийн эх (Цьюань.). Бээжин, 1988.
14. Чэнь Гохуа. юан улсын их нийслэл (Юань даду). Бээжин. 1982.
- 15: Елюй Чуцай, Номхон даяанчийн зохиолын эмхтгэл (Чжанжан цзюйши вэньцзи).
16. Ж. Раднаабазар. Угийн бичиг.